

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 07 дугаар сарын 24-ний өдөр

№ 23/22

Улаанбаатар хот

Нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаасны нөхцөлийг баталгаажуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дэх хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.2, 41.3 дахь хэсэг, 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.5, 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.2, 80.4 дэх хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 226 тоот “Компанийн өрийн хэрэгслийн бүртгэх журам”, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”) -ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.2, 9.6.4 дэх заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 23/11 тоот тогтоолоор батлагдсан “Компанийн 2023 оны эх үүсвэрийн төлөвлөгөө”, Компанийн ТУЗ-ийн 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 23/20 тоот тогтоол, Компанийн ТУЗ-ийн 2023 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**


1. Компанийн зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор 100,000 (нэг зуун мянга) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 90,000 (ерэн мянга) ширхэг, нийт 9,000,000,000.00 (есөн тэрбум) төгрөгийн үнийн дүн бүхий Компанийн өрийн хэрэгсэл (цаашид “Лэнд Бонд”)-ийг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд санал болгон арилжаалахаар гаргах болсныг баталгаажуулсугай.
2. Нийтэд санал болгох Лэнд Бондын хэмжээ, төрөл, хугацаа, хүүгийн хэмжээ, хүү төлөх хугацаа, үнэт цаасны нөхцөлийг энэхүү тогтоолын Хавсралт №1-ээр шинэчлэн баталсугай.
3. Лэнд Бондыг нийтэд санал болгон гаргахтай холбоотой ажлын үйл явц, үр дүн болон энэхүү тогтоолын хэрэгжилтийн талаар Компанийн ТУЗ-д танилцуулахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.
4. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Компанийн ТУЗ-ийн 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 23/20 тоот тогтоолын хавсралтыг хүчингүй болгосугай.



ТУЗ-ИЙН ДАРГА

О.БОЛДБААТАР

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2023 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн
23/22 тоот тогтоолын хавсралт



НИЙТЭД САНАЛ БОЛГОХ ҮНЭТ ЦААСНЫ НӨХЦӨЛ

1.	Үнэт цаас	Нээлттэй арилжаалах өрийн хэрэгсэл “Лэнд Бонд”
2.	Арилжаа эрхлэх байгууллага	Монголын хөрөнгийн бирж
3.	Лэнд Бондын нэрлэсэн үнэ	100,000 (нэг зуун мянга) төгрөг
4.	Тоо ширхэг	90,000 (ерэн мянга) ширхэг
5.	Олон нийтэд санал болгох нийт дүн	9,000,000,000 (есөн тэрбум) төгрөг
6.	Хүү (жилийн буюу 365 хоног)	18.0% (арван найман хувь)
7.	Бондын төрөл	Энгийн хүүтэй бонд
8.	Лэнд Бондын хугацаа	24 (хорин дөрөв) сар
9.	Хүү төлөгдөх давтамж	Улирал тутамд
10.	Үндсэн төлбөр төлөх хугацаа	Лэнд Бондын хугацааны эцэст (24 сарын дараа)
11.	Лэнд Бондын барьцаа/Баталгаа	“АНД Системс” ХХК-ийн эзэмшиж буй 13,600,000,000 (арван гурван тэрбум зургаан зуун сая) төгрөгийн үнэлгээ бүхий 400,000,000 (дөрвөн зуун сая) ширхэг “ЛэндМН ББСБ” ХК-ийн хувьцаа
12.	Татан төвлөрүүлсэн хөрөнгийг зарцуулах зориулалт	Үнэт цаас гаргагчийн зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлнэ
13.	Нийтэд санал болгон гаргах хугацаа	2023 оны III улирал (Зохицуулагч байгууллагаас шалтгаалан өөрчлөгдөх боломжтой)
14.	Лэнд Бондын хадгалалт, төлбөр тооцоо	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-аар дамжуулан гүйцэтгэнэ
15.	Үндсэн андеррайтер	“Райнос Инвестмент ҮЦК” ХХК
16.	Туслах андеррайтер	Гүйцэтгэх захирал нь үндсэн андеррайтер “Райнос Инвестмент ҮЦК” ХХК-тай харилцан тохиролцож, нэмэлтээр туслах андеррайтер ажиллуулж болно